



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 17 өдөр

Дугаар А/21

Хархорин сум

**Сумын хууль, эрх зүйн сургалт,
сурталчилгааны ажлын 2025 оны нэгдсэн
төлөвлөгөөг батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, Засгийн газрын 1996 оны "Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" 66 дугаар тогтоолын 5 дахь хэсэг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Хархорин сумын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай" 02/10 дугаар тогтоолын 71 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сумын хууль, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Сумын хууль, эрх зүйн сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан байгууллага бүр эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, тайлагнан ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Эрх, зүйн сургалт сурталчилгааг хэрэгжүүлэх зардлыг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Х.Лхагвадулам)-д зөвшөөрсүгэй.

4. Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн (Н.Нямдаваа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  **Б. БАТ-ЭРДЭНЭ**

